

ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/29

Сүмбэр сум

Үндсэн хөрөнгө орлогодох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Сангийн сайдын 2016 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийнн өмчийн хуулийн этгээдэд өмчийн харилцаа зохицуулах журам”-ын 3.1, 3.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 18 500 000 /арван найман сая таван зуун мянга/ төгрөгийн үнэ бүхий Mitsubishi-delica маркын автомашиныг үндсэн хөрөнгийн данс, санхүүгийн тайланд тусгахыг нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

2. Автомашины ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцан, хяналт тавьж ажиллахыг өмч хамгаалах байнгын зөвлөлд даалгасугай.

ДАРГА

Ц.ОЮУНБИЛЭГ

